



АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЛИЙН УДИРДЛАГЫН
АНХААРАЛД

Хандивын тайлан ирүүлэх тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д “Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасан.

Иймд Аймгийн намын хороо болон сумууд дахь намын салбар байгууллагуудын 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс 2020 оны 06 дугаар сарын 01-ний хооронд авсан хандивын тайланг хавсралт 1, 2 дугаар маягтаар гаргаж арилжааны банкин дахь дансны баталгаажсан хуулгын хамт 6 дугаар сарын 24-ний дотор ирүүлэхийг мэдэгдье.

Хандивын тайланг 6 дугаар сарын 24-ний өдрийн 17 цаг хүртэл аймаг дахь Төрийн аудитын газрын аймгийн Засаг даргын тамгын газрын 1 дүгээр давхарын 106, 108 тоот өрөөнд хүлээн авна.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2020.06.17

8317144071

БЮА0074 9007245

Энэхүү зарыг Орон нутгийн олон нийтийн радиогоор
2020 оны 6 дугаар сарын 17, 18, 19 өдрүүдэд нэвтрүүлсэн байна.